

**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2023 оны .... сарын .... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

“Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйлчилгээний  
төлбөр, хураамж”-ийг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.10, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн спот болон форвард гэрээг байгуулахтай холбогдох арилжаанаас авах үйлчилгээний төлбөр, хураамжийн дээд хязгаарыг тухайн арилжааны үнийн дүнгийн 1.0 хувиас ихгүй байхаар тогтоосугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан төлбөр, хураамжийн дээд хязгаарыг холбогдох дүрэм, журамдаа тусгаж, мөрдөж ажиллахыг уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН